

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А-1/1931 дүгээр албан бичгийн хавсралт

**“АЛСЫН ХАРАА – 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

**ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2025 оны жилийн эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр)

**Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар**

2025.10.07

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2025 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7
<b>ТАВ. ЗАСАГЛАЛ</b>						
1	5.2. Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилсна.	5.2.19. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.	2020 - 2050	-	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөжийг 10 хувьд хүргэнэ; Алдагдалтай ажилласан төрийн	<b>ТӨБЭГ – ТӨУЗХ</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 67 (толгой компанийн тоогоор) хуулийн этгээдийн 2024 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн дүнгээр хөрөнгийн өгөөж дунджаар 9.6 хувьтай байна. (Х1-96.0%) 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн дүнгээр алдагдалтай ажилласан төрийн өмчит хуулийн этгээд төрийн өмчит нийт компанийн 25.2 хувийг эзэлж байгаа дүнтэй байна. (Х2-81.3%) Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үр ашгийг нэмэгдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, оновчтой тогтоох, удирдлагын зардал, орон тоог бууруулах зорилгоор 2025 онд Засгийн газрын холбогдох шийдвэрээр төрийн өмчит 18 компанийг нэгтгэн 8 хуулийн этгээд болгон зохион байгуулсан. "Аялал жуулчлалын хөгжлийн төв" ТӨҮГ-ыг татан буулгасан.

					<p>өмчит хуулийн этгээд 2024 онд төрийн өмчит нийт компанийн 33.6 хувийг эзэлж байсныг 31.0 хувь болгож бууруулна.</p>	<p>Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор захиргаа хүнийг нөөц, санхүү, олон нийттэй харилцах, маркетинг болон үнэлгээ, мониторинг, гадаад харилцаа зэрэг ижил төрлийн зарим үүргийг нэгтгэж, зардал бууруулах, нэгдсэн менежмент хэрэгжүүлж, хяналт тавих үүрэг бүхий “Эрчист Монгол” ХХК-ийг Засгийн газрын 2025 оны 04 дүгээр тогтоолоор байгуулж, зам, тээвэр, хөдөө аж ахуй, санхүү, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулж буй 44 төрийн өмчит компанийг нэгтгэн харьяанд нь ажиллуулж байна.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон тоог 10-аас доошгүй хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг 15-аас доошгүй хувиар бууруулах чиглэлийг төрийн өмчит хуулийн этгээдүүдэд хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Тухайлбал, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын орон тооны дээд хязгаарыг 10 хувиар буюу 76 орон тоогоор бууруулсан ба 3.0 тэрбум төгрөгийн, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын орон тооны дээд хязгаарыг 10 хувиар буюу 26 орон тоогоор бууруулж, 700.0 гаруй сая төгрөгийн хэмнэлтийг тус тус гаргаад байна.</p> <p>Өмч хувьчлалыг үр дүнтэй үе шаттай явуулах хүрээнд “Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах” үндсэн чиглэлд 9 хуулийн этгээдийн энгийн хувьцааг нэмж гаргах, хувьцаа гаргах бэлтгэл хангах, биржээр олон нийтэд нээлттэй худалдах, нээлттэй хувьцаат компани болгож, өөрчлөн байгуулахаар тусгасан. Уг үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд 2,326.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх боломжтой гэж тооцоолсон. Үүнээс 120.0 тэрбум төгрөгийг 2026 онд төвлөрүүлэхээр тооцож, улсын төсвийн төсөлд тусгасан болно.</p> <p><b>Хэрэгжилтийн явцын дүн: 88.7 хувь буюу “Үр дүнтэй”</b></p>
2	5.6. Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.	5.6.8. Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна.	2020 - 2050	-	Цахим системийг улсын хэмжээнд ашиглалтад нэвтрүүлнэ. Өмчийн харилцааны мэдээллийн нээлттэй	<p><b>ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ</b></p> <p>1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл харууцагчаас байнга нээлттэй байлгах мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлэх арга хэмжээг эрчимжүүлэхэд анхаарч, хяналт тавин ажиллав. ТӨБЗГ нь үйл ажиллагааныхаа хүрээнд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар байгууллагын албан ёсны цахим хуудаст 75, фейсбук пэйж хуудаст 38, шилэн дансны цахим системд 126, мэдээллийн самбарт 15, бусад хэвлэл мэдээллийн сувгаар 25,</p>

				<p>байдал хангагдана.</p>	<p>нийт 279 мэдээ, мэдээллийг шинээр байршуулан олон нийтэд мэдээлсэн байна.</p> <p>Засгийн газрын шилэн ажиллагааны цахим хуудас <a href="https://shilen.gov.mn">https://shilen.gov.mn</a> -д зарласан нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний дүнгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2024 оны жилийн эцэст 58 хувийн үнэлгээ авсан бол 2025 оны 1 дүгээр улиралд 82 хувийн үнэлгээ авсан үнэлгээг ахиулсан үр дүнтэй байна. Холбоос: <a href="https://shilen.gov.mn/index">https://shilen.gov.mn/index</a></p> <p>2. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах, нийтийн өмчийн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлаарх саналаа 2025 онд Монгол Улсын Их Хуралд Засгийн газраас өргөн мэдүүлээд байгаа Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төсөл болон Нийтийн өмчийн хуулийн төсөл (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга)-д тусгуулах арга хэмжээ авсан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 13 дахь хэсэгт өөрчлөлт орсонтой холбогдуулан төрийн өмчит компани болон үйлдвэрийн газруудын захирал, гүйцэтгэх захирлуудтай байгуулах Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах, эрх бүхий байгууллагад тайлагнах үүрэг, хариуцлагыг тодорхой тусган хуулийн хэрэгжилтийг хангаж байна.</p> <p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох зорилт, арга хэмжээ, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2025 онд 21 аймгийн Орон нутгийн өмчийн газарт “Зөвлөмж”, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 67 хуулийн этгээдэд “Чиглэл” хүргүүлэв. Төрийн өмчит 55 хуулийн этгээд үйл ажиллагаа, холбогдох мэдээллийг нийтэд ил тод мэдээлдэг талаар баримтжуулан ирүүлсэн бөгөөд ТӨБЗГ-ийн харьяа 21 байгууллагын хувьд 17 байгууллага нь буюу 81% нь өөрийн цахим хуудастай, цахим хуудсаараа дамжуулан Ил тод байдал үндсэн цэс үүсгэн, тус цэсэнд 2-11 төрлийн дэд цэс үүсгэн холбогдох мэдээллийг байршуулан олон нийтэд ил тод болгоод байна.</p>
--	--	--	--	---------------------------	---

						<p>Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтээр гүйцэтгэж байгаа нийт 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий "Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн систем"-ийг шинээр бий болгож, улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлыг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэхээр ажиллаж байна. Уг системд өмчийн мэдээллээ оруулах төрийн болон орон нутгийн өмчийн 7000 гаруй хуулийн этгээдэд зааварчилга өгөх, чиглүүлэх "сургагч багш"-ийг бэлтгэх ажлыг улсын хэмжээнд 9-10 дугаар сард зохион байгуулж байна. Систем ашиглалтад нэвтэрснээр төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, зохион байгуулалт, бүртгэл, ашиглалт, хяналтын асуудал цахимжиж, өмчийн харилцааны мэдээллийн солилцоо, нээлттэй байдал хангагдана.</p> <p><b>Хэрэгжилтийн явцын дүн: 85.0 хувь буюу "Үр дүнтэй"</b></p>
--	--	--	--	--	--	---

**ХЭРЭГЖИЛТИЙН ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА (өөрийн дүн):**

"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэгт шууд хамаарах Засаглалын бодлогын хүрээний 2 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 2 арга хэмжээний хэрэгжилтийг тайланд тусгасан болно. Эдгээр зорилт, арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийг хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр тайлагнаж байгаа бөгөөд дунг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 6.5-д заасан арга зүй, аргачлалын дагуу хяналт-шинжилгээ хийж, дүгнэн дор товчлон танилцуулав.

**Дүнгийн товч танилцуулга (2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр):**

Нийт арга хэмжээ (заалт)-ний тоо – 2;

Үүнээс: 2 арга хэмжээ – 85.0 хувь буюу түүнээс дээш хувийн хэрэгжилттэй буюу "Үр дүнтэй" хэрэгжиж байна.

"Алсын хараа – 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцын дундаж дүн – **86.8 хувь буюу "Үр дүнтэй"** гэж дүгнэж байна.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА **Б.ЦЭНГЭЛ**



Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Н.ГАНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА 

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН



Д.ЦЭРЭНЛХАМ